

Батлав: ҮТС-ийн захирал, доктор (Ph.D), дэд проф. Ж.Туяацэцэг



**“Биотехнологи бидний амьдрал - 2023”
цахим бүтээлийн уралдааны удирдамж**

ЗОРИЛГО

“Биотехнологи бидний амьдрал – 2023” цахим бүтээлийн уралдаан нь Монгол улсын Засгийн газраас шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл болгон зарласан Биотехнологи мэргэжлийн үнэ цэнийг олон нийтэд, тэр дундаа Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад ойлгуулах, ач холбогдлыг сурталчлах, тэдний шинжлэх ухааны ойлголтыг дээшлүүлэх;

БҮТЭЭЛИЙН ДЭД СЭДЭВ

- a. Биотехнологи бидний ирээдүй
- b. Биотехнологи ба хүнс
- c. Экологи ба биотехнологи
- d. Хүнсний аюулгүй байдал

ХАМРАХ ХҮРЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн 11-12 ангийн сурагчид

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн бүрэлдэхүүн сургууль болох Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Биотехнологи, шим тэжээлийн салбар

БҮТЭЭЛИЙН БҮТЭЦ

“Биотехнологи бидний амьдрал” цахим бүтээлийн уралдааны ирүүлэх бүтээл нь аль нэг дэд сэдвийн агуулгад нийцсэн байна. Бүтээлийг видео, богино шторк зэрэг хэлбэрээр бэлтгэнэ. Үргэлжлэх хугацаа 3-4 минут байна. Бүтээлийг 11-12 ангийн 5-10 сурагчид баг болж хийж болно. Бүтээл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Бүтээлийн нэр
- Үндсэн хэсэг
- Бүтээлийг хийсэн багийн гишүүдийн танилцуулга, сургуулийн нэр, анги, удирдаж чиглүүлсэн багштай бол багшийн нэр, холбоо барих утасны дугаар, мэйл хаяг

ХҮЛЭЭН АВАХ БОЛОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Бүтээлийг 2023 оны 3-р сарын 24-нд munhzaya_h@must.edu.mn (99101340), soyol_d@must.edu.mn (86080295) хаягаар хүлээн авна. Шалгаруулалтыг 2023 оны 3-р сарын 24-31-ны хооронд мэргэжлийн багш, судлаачид явуулна. Хэрэв бүтээлийг шууд хуулбарласан, хугацаа хоцроосон тохиолдолд шалгаруулалтанд оролцуулахгүй болохыг анхаарна уу.

ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

1. Тэргүүн байр /1 бүтээл/ - өргөмжлөл, 120000 төгрөг
2. Хоёрдугаар байр /1 бүтээл/ - өргөмжлөл, 100000 төгрөг
3. Гуравдугаар байр /1 бүтээл/ - өргөмжлөл, 80000 төгрөг
4. Тусгай байр /2 бүтээл/ - өргөмжлөл, 25000 төгрөг